

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2024.06.20

ХӨДӨӨ АЖ АХУЙ САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Бэлчээрийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийгдлээ.

Байгалийн гамшгаар хорогдсон үхсэн малын сэг зэмийн устгалын ажил 35 цэгт байгуулан, тэмээ-23, адуу-15564, үхэр-25836, хонь-144766, ямаа-74869, нийт 260896 сэг зэмийг устгасан.

Устгалын 35 цэг, 50 малчин өрхийн хашаа хороо нийт 297500 м2 талбайд малын гоц халдварт, халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халдваргүйжүүлэлт хийлээ.


Малчдын бүлгийн оролцоонд тулгуурлан бэлчээр ашиглалтыг сайжрууллаа.

02 дугаар
05-р сарын 3
малчдын сууриар
гаруй малчин
хүсэлтийг
толгой эрс буурч
хорогдсон байна.




сарын 10-ны өдрөөс
сарын хугацаанд
2 удаа тойрч, 250
өрхөөр орж, санал
сонслоо. Малын тоо
нийт малын 66,1 хувь

**Цөөн малтай
залуучуудыг малжуулах
төсөлд хамрууллаа.** Байгалийн
гамшигт үзэгдлээс 971 малчин
өр 200 хүртэлх толгой малтай
болсон байна. Үүнээс тус сумын
51 малчны материалыг
амьжиргаа дэмжих зөвлөлийн
хурлаар хэлэлцэн дэмжиж,
аймгийн ХХҮГазарт хүргүүлээд
байна.



**Залуу малчдыг
малчдын бүлэг
хоршоонд хамруулан,
хөдөлмөрийг хорших,
хамтын хөдөлмөрийн
давуу талыг
ойлгуулахад анхаарч
ажиллалаа.**

Монгол Улсын
Засгийн газраас “Хоршоо
хөгжүүлэх” аяныг зарлан,



малчдын хоршоо бүлгийг дэмжин ажилласан бөгөөд тус сумын хэмжээнд мал аж ахуйн чиглэлээр 32 хоршоо шинээр байгуулагдсан байна.

Мал сүргээ тогтвортой өсгөж, амжилт гаргаж байгаа залуу малчдыг орон нутгаас урамшуулж ажиллалаа. 2024 оны босгон дээр олон жил үр дүтээлтэй ажиллаж хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлсэн Улсын аварга малчин-1, аймгийн аварга малчин-4, сумын аварга малчин 6 тус тус тодорсон.

Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр мал аж ахуйн салбарт үлгэрлэн ажиллаж байгаа малчны хөдөлмөр зүтгэлийг сурталчилсан нэвтрүүлэг хийж, олон нийтийн хүртээл болголоо.

Өвөлжилтийн хүнд нөхцөл байдалд бог малын хохирол хэдий амссан ч бод малаа хорогдол багатай авч үлдсэн 8-р багийн залуу малчин, сумын аварга малчин Ариунболдын суурьт НҮБ, аймгийн ХХААГазар, FAO Олон Улсын байгууллага, МҮОНТР-ын нэвтрүүлгийн албатай хамтран мэдээлэл бэлтгэсэн.


Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт мэдээллийн ажил зохион байгууллаа.

Сүхбаатар аймгийн алдсан малын нэгдсэн зарын групп нь 2024 оны 06-р сарын 08-ны өдрийн байдлаар 992 гишүүнчлэлтэй болсон байна.

Сумын Засаг даргын 2024 оны А/06 дугаар захирамжаар Мал, амьтны отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, малын хулгайтай тэмцэх, хуулийг сурталчлан таниулах зорилго бүхий отрын штабыг байгуулж, 450 иргэнд мэдээлэл хүргэсэн.

Алдуул малыг бусдын өмчлөл, эзэмшилд байгааг мэдсээр байж завшвал эрүүгийн хариуцлага хүлээх тухай хуулийн зүйл, заалт тайлбар бүхий мэдээлэл бэлтгэж 75 өрхөд хүргэсэн.

Хүлэмжийн аж ахуйн талбайн, ургацыг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.



Хагас жилийн байдлаар 15 иргэн 2 аж ахуй нэгж байгууллага нийт 0,06 га талбай бүхий зуны нийлэг хүлэмжийг ашиглаж 6 нэр төрлийн нарийн ногоог тариалаад байна.

Хөдөө аж ахуйн цогцолборт төмс хүнсний ногоо тариалах сонирхол бүхий иргэдэд талбай олгож, агропаркын үйл ажиллагааг эрчимжүүлж байна.

Төмс хүнсний ногоо тариалалт хийх сонирхолтой 8 иргэн талбайн хагалгаа, үрэлгээ хийж нийт 0,8 сот газарт төмс, 0,1 сот газарт ногоон сонгино, 0,1 га талбайд манжин, 200 м2 талбайд хүлэмжид нарийн ногоо тариалсан.

Төмс хүнсний ногоо тариалах иргэн, ААНБ-ыг дэмжиж тариалалтыг нэмэгдүүлэн дотоодын хэрэгцээг хангах зорилго тавин ажиллаж байна.

Хаврын тариалалтаар нийт 15 иргэн, 3 аж ахуй нэгж төмс, хүнсний ногоо 5.2 га талбайд тариалсан ба үүнээс 3,0 га талбайд төмс, 2,1 га талбайд 3 төрлийн хүнсний ногоо, үүнээс 0,06 га талбайд хүлэмжийн 2 төрлийн ногоо тариалсан.

Жимс жимсгэний мод суулгацын тоог нэмэгдүүлнэ.Хаврын тариалалтын мэдээгээр аймгийн ХХААГазар 2 төрлийн 2 настай үхрийн нүд, интоорын суулгац, 500 ш жимс жимсгэний мод суулгасан.

Малын хагас жилийн тооллого:Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Малын хагас жилийн тоо мэдээг зохион байгуулах ажлын хэсэг сумын Засаг даргын 2024 оны А/132 дугаар захирамжаар байгуулагдан 05-р сарын 27-ны өдрөөс 06-р сарын 04-ны өдрийн хооронд 7 хоногийн хугацаанд үндсэн 4 групп 12 албан хаагч 3 техниктэй сонгогдсон 341 өрхийн мэдээллийг цуглуулж нийт 26,1 мян.толгой мал тоолсон.

Хагас жилийн мал тооллогын ажилд хяналтад тавьж ажиллалаа.

2023-2024 оны өвөлжилт хаваржилтын хүнд нөхцөл, байдлаас шалтгаалан малын хорогдол өндөр байгаа тул тооллогын ажилд Үндэсний статистикийн хорооноос ажлын хэсэг ирж хяналт тавьж ажилласан. Хяналтыг сумын тамгын газрын мэргэжилтэн Н.Гантөмөр, аймгийн хяналтаар аймгийн Статистикийн хэлтсийн мэргэжилтэн н.Мөнхбаяр, улсын хяналтаар ҮСХорооны мэргэжилтэн н.Ихэртөр, н.Тэлмэн нар ажиллаж, мал тооллогод сонгогдсон 5 өрхөөр орж хяналт тавьж, нэг өрх сонгон малыг нүд үзэж тоолсон.



Ажлын хэсэг томилогдон өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцлаа.

Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцаж, 3 удаа малчдын сууриар тойрч нийт 120 хот айл, 222 өрхийн 250 иргэнтэй уулзан санал бодлыг сонсож, удирдлагад уламжлан, шийдвэрлэж ажиллалаа.

Отрын штаб байгууллаа. Сумын Засаг даргын 2024 оны А/06 тоот захирамжаар Мал, амьтны отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах отрын штабыг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс **04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл** Эрдэнэцагаан сумын нутаг Лагын нуур, Матад сумын Хонгорын овоо гэдэг газарт байгуулсан.


Отрын штабт давхардсан тоогоор 470 гаруй малчин ирж, 220 эрэлчин хоноглосон. Отрын штабаар ирсэн эрэлчдэд халуун хоол цайгаар үйлчлэн, эрүүл мэндийн үзлэг хийж, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн. Отрын штабт ажилласан ажлын хэсэг уруудсан адууны зураг авч, бичлэг хийн, цахим хуудсанд байршуулснаар малчид адууныхаа сургийг гарган, мэдээлэл солилцсон. Уг ажилд 14.450.500 зарцуулсан.



Малчид, иргэдийн санал хүсэлтийн дагуу сумын шуурхай штаб нь 9 удаа зам нээх ажлыг зохион байгуулсан. Үүнд:

1. Дорнодын зам дагуу 20-н овоо хүртэл 40 км замыг аймгийн Онцгой байдлын газартай хамтран трактор, тальпуу ашиглан гаргасан.
2. Дорнодын зам дагуу 20-н овоо, тахилгат, зүүн амгалан, Баруун тариа, Цогт, Энхамар чиглэлийн 210 км замыг нээх ажлыг Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазартай хамтран Ковшийг ашиглан гаргасан.
3. Энхамар, Баруун тариа, Амгалан, Тахилгат, Мянгат чиглэлд 250 км зам нээх ажлыг аймгийн Онцгой байдлын газрын ковшийг ашиглан гаргасан.
4. Хар худаг, Шаргын уул, Шовдол чиглэлд 120 км замыг аймгийн Онцгой байдлын газрын ковшийг ашиглан гаргасан.
5. Буян овоо цагаан овоо чиглэлд 120 км зам гарсан.
6. Сумын ИТХ-ын дарга Т.Ихбаяраар ахлуулсан ажлын хэсэг Монгол зам ХХК-ны ковштой, Баруун-Урт сумын нутгийн зөвлөлийн төлөөлөлтэй зүүн хойд зүгт 350км айл өрхийн хоорондын замыг нээсэн. Үе Цэгээн, Яргайт, Хэсгийн толгод 28 өрх, 109км зам нээсэн.

малчидтай хийсэн уулзалт




Зам гарц нээх



7. Хэсгийн толгод, Адуу чулуу, Тариа орчим нутаглаж буй 30 өрх, 78км зам нээсэн.

8. Баруун тариа, Өлгий, Шанд, Сувилал орчин нутагдаж буй 19 өрх, 102км зам, нийт 1379 км замыг тус тус нээсэн.Тус ажлын зардалд 20,6 сая. төгрөг зарцуулсан.

Сумын Онцгой комисс, Шуурхай штабт 10 удаагийн дуудлага мэдээллээр сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн аврах бүлгийн давхардсан тоогоор 53 албан хаагч, 10 тээврийн хэрэгсэл дайчлагдан ажилласан байна. Дуудлаганд нийт 1,375,400 төгрөгийн шатахууныг зарцуулсан байна.



Сумын онцгой комиссын хуралдааны шийдвэрээр боодол өвс, 2 уут хивэг, мал боодол өвсийг үнэ төлбөргүй гаргаж 3 ээлжээр 1073 малчин өрхөд 15800 боодол өвс, 6670 шуудай улаан буудай үнэ үлдэгдэл 350 уут хивэг, улаан багсармал тэжээл 85 уут, нөөцийн агуулахад байна.



2024 оны 01 дүгээр малчин өрхөд 9 бүхий өрхөд 5 олгох шийдвэрийг өрх, 594 мал бүхий шуудай хивэг, 3995 төлбөргүй олгож буудай 540 уут, хорголжин 240 уут

Малчид иргэдийн түлшний хангалтыг нэмэгдүүлж, нүүрс олголтын ажлыг зохион байгууллаа. Аймгийн Засаг Даргын 2024 оны А/04 тоот захирамжаар Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал зарласан. АОК-ын шийдвэрээр гэр хорооллын айл өрхүүдэд

нүүрсний дэмжлэг үзүүлэх ажил хийгдэж баг тус бүрт 100тн нүүрсийг буулгах ажлыг Хот тохижилт ОНӨАТГ Дөрвөлж



ОНӨААТҮГазар тус сумын мэргэжлийн зориултын 18 албан хаагч Онцгой байдлын газрууд хамтран ажиллалаа. 1,2,3,4-р багууд багийн нутаг дэвсгэрт 5,7,8-р багууд хот тохижилтын хашаанд 6,9 багууд 5-р багийн нутаг дэвсгэр дээр тус тус 6 цэгт 9-н багийн ажлын алба иргэдэдээ түгээж ажилласан.

Цасанд дарагдсан айл өрхүүдийг цэргийн ангийн дэмжлэгтэй гаргах ажлыг зохион байгуулсан.Цасанд дарагдсан мэдээллийн дагуу ЗХ-ны 327-р ангийн албан хаагчид ирж ажиллан 309 өрхийг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулсан



Шар усны үерээс урьдчилан сэргийлэх, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулсан. Шар усны үер автах эрсдэлд орсон 7 айл өрхийг нүүлгэн шилжүүлэх ажил хийгдсэн ба шар усны үер автах эрсдлийг бууруулж их хэмжээний цасыг хусч цэвэрлэсэн. Тус ажилд 4 техник 15 албан хаагч ажилласан.

Иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгууллаа.Малын сэг зэмийн устгалд малчдыг уриалах, мэдээллэх соён гэгээрүүлэх ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 4 ажлын хэсэг 16 хүний бүрэлдэхүүнтэй 8 тээврийн хэрэгслээр 2 өдөр нийт 56 өрхөөр орж иргэдэд мэдээ мэдээлэл өгсөн

Шар усны үерээс урьдчилан сэргийлэх, аврах арга хэмжээ авч, ажиллалаа.



Хүнс хөдөө аж ахуйн чиглэлээр: Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах тов зарлах болсонтой холбогдуулан “Бизнес төсөл боловсруулах аргачлал” хоршооны тухай ойлголт сэдэвт сургалт зохион байгуулсан. Тус сургалтад нийт 41 иргэн, хоршооны төлөөлөл хамрагдаж бизнес төсөл боловсруулах аргачллын талаар мэдээлэл авсан.

Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах товыг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн баталж, 2024 оны 04 дүгээр сарын 15-аас нэг сарын хугацаанд хүлээн авсан. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлд “Бумт алтан шаглаа”, “Хурдан саарал” хоршоо нар материал ирүүлж, сонгон шалгаруулах зөвлөл 100 хувийн ирцтэй хуралдаж, Хурдан саарал хоршооны Европ блок үйлдвэрлэл төсөлд 40,000,000 сая төгрөгний зээлийг олгохоор шийдвэрлэлээ.

Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын хэсгийн байцаагч Х.Сүхболд, А.Ганжаргал, Сүхбаатар аймгийн Татварын газрын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Э.Алтангэрэл, П.Билэгтсайхан нартай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулж, тус сумын 1 дүгээр багт үйл ажиллагаа явуулдаг Исгэрээ дэлгүүрт улсын онцгой албан татварын тэмдэггүй 14 шил согтууруулах ундааг дэлгүүрийн лангуун дээр байршуулж байсныг ажлын хэсэг хураан авч, зөрчлийн хэрэг үүсгэн орон тооны бус зөвлөлд ирүүлж, зөвлөл хуралдан устгах шийдвэр гаргалаа.

“Үйлдвэрлэгч аймаг болцгооё” уриан дор Сүхбаатар аймгийн бизнес эрхлэгчдийн долоодугаар зөвлөгөөн зохион байгуулагдлаа. Аймгийн нийгэм, эдийн засгийг сэргээх, худалдаа, жижиг дунд үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг сайжруулах, чадавхжуулах зорилго бүхий ээлжит зөвлөгөөнийг Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны санаачилгаар аймгийн ХХААГазар, Сүхбаатар хөгжил ҮТП, ХАҮТ, Хоршоологчдын холбоо, Монголын ХХАА үндэсний ассоциаци, Жанжны нутгийн худалдааныхан ТББ хамтран зохион байгуулсан.

Тус зөвлөгөөнд сумын жижиг дунд үйлдвэр эрхлэгч, хоршоо, үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл болсон 71 иргэн хамрагдсан.

Бизнес эрхлэгчдийн хувьд хөнгөлөлттэй зээлд хамрагдах, ажлын байрны хүртээмж, ажиллах хүчний хомсдол зэрэг тулгамдаж буй нийтлэг асуудлыг хөндөж, холбогдох шатны мэргэжилтэн, шийдвэр гаргагчдаас мэдээлэл авч, санал бодлоо солилцсон.

“Эко сав хэрэглэж хэвшье” аяны хүрээнд тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хэрэглэдэг хуванцар савны ашиглалтын талаар судалгаа явууллаа.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 60 хувь нь шаардлага хангаагүй усны сав ашигладаг болох нь тодорхойлогдсон.

Судалгааны дүнд үнэдслэн сурагчдад стандартын шаардлага хангаагүй хуванцар ус, хоолны савны хор хөнөөлийг сурталчлан таниулж, эко сав хэрэглэхийг уриалж ажилласан.

“Монгол Улсад хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн салбарыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Иргэний нийгмийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” хэлэлцүүлгийг сумын Тамгын газар, ЛЭОСантай хамтран 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгууллаа.



Хэлэлцүүлэгт ИНБ-ын 21 төлөөлөл оролцсон бөгөөд ЭЗОС үндэсний сүлжээ, ЛЭОС ТББ-ын тэргүүн Ц.Бүжидмаа “ИНБ-ын өнөөгийн байдал, оролцоо, олон улсын зарим туршлагаас цахимаар мэдээлэл өгч, оролцогчдын сонирхсон асуултад хариулж, харилцан мэдээлэл солилцоо.

Хууль эрх зүй зүйн чиглэлээр: Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газраас “**ЗӨВ ХЭВШИЛ- ЗӨВ АМЬДРАЛ**” хөтөлбөрийг 4 дэх жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд 2024 онд эрүүл зохистой хооллолт, утаат болон электрон тамхины хор уршгийг иргэдэд сурталчлан, таниулах зорилт тавин ажиллаж байна.



Тайлант улиралд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн.Үүнд:

Энэхүү зорилтын хүрээнд “ИЛҮҮДЭЛ ЖИНГҮЙ-ЭРТЭЧ СҮХБААТАРЧУУД” бүх нийтийн гүйлтэд оролцсон төрийн албан хаагчид болон иргэдийг зөв зохистой хооллож, эрүүл амьдралын дадлыг хэвшүүлэх, буруу дадал, зуршлаас татгалзахыг уриалж ажиллалаа.



“Электрон тамхины хэрэглээ, түүний хор уршиг” сэдэвт сургалтыг 7 дугаар багийн ИТХ-ын төлөөлөгч Д.Барцэцэгтэй хамтран тус сумын 3 дугаар бүрэн дунд сургуулийн 6-12 дугаар ангийн 200 гаруй сурагчдад зохион байгуулж, гарын авлага, тараах материал олголоо.Сургалтын дүнд тамхины хор хөнөөл, гарч болох эрсдлийн



талаар мэдлэг, мэдээлэл өгсөн.

Баруун-Урт суманд ажиллаж, амьдарч буй 30-с дээш насны залуучуудын дунд сагсан бөмбөгийн лигийн тэмцээнийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, спортоор хичээллэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, амьдралын зөв дадал хэвшүүлэх зорилгоор 1 улирлын турш зохиог байгууллаа.

Тэмцээнд нийт эрэгтэй 6 багийн 80 гаруй тамирчид өрсөлдөж аварга багаа шалгаруулсан. **Тэмцээний үеэр зохион байгуулагдсан онцлог үйл ажиллагаануудаас дурдвал:**

Анх удаа лигийн тэмцээнд хувь тоглогчийн статистик үзүүлэлтийг хөтөлж явуулснаараа онцлог байлаа. Тамирчид өөрсдийн статистик довтолгооны хувиа харж дүгнэлт хийж явсан.

Багууд дасгалжуулагч авч ажиллуулсан. Дасгалжуулагч авсан багууд илүү амжилт үзүүллээ.

Тэмцээний нээлтийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан

Тэмцээний нээлт, хаалтын үйл ажиллагааг BBS тв-н мэдээгээр дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргүүлж ажилласан.

Сошиал медиа хариуцсан хүнтэй хамтран ажиллаж бүх үйл ажиллагааг постер , богино reel бичлэгүүд, финалын тоглолтуудыг live хийж шууд дамжуулах зэргээр ажилласан,

Тэмцээнийг зохион байгуулалт тамирчидын сахилга баттай байлгах үүднээс зөрчил гаргасан тамирчдад тухай бүрт торгууль шийтгэлийн ноогдуулж явсан

Заал танхимд орохдоо нэг удаагийн улавч өмсөж соёлтой байх, архи тамхи татахгүй байх, шүлс нусаа хаяхгүй байх зэрэг урилгуудыг гаргаж ажилласан

Тэмцээний шагналын сан өндөр, АВАРГА багт тусгайлан аваргын малгай, фудволк гардуулсан.

Тэмцээний улирлын үнэ цэнэтэй тоглогчоор Ёст бэйс сервис багийн төвийн тоглогч О. Алтангэрэл,

Финалын үнэ цэнэтэй тоглогчоор Ёст бэйс сервис багийн довтлогч М. Мөнхсүх нар шалгарлаа.

Анхдугаар тэмцээний шилдэгүүд: Тэргүүн байр АВАРГА багаар Диваагийн Амартүвшин эзэнтэй Ёст бэйс сервис

- ДЭД аваргаар Сарангэрэл Батхүү эзэнтэй Цайртминерал ХХК
- ГУТГААР байранд Болдын Ариунболд эзэнтэй Хатан туул хөгжил ХХК-ын багууд тус тус шалгарлаа.

Тэмцээний үр дүнд: Тэмцээнд оролцсон тамирчид 5-10 кг-р илүүдэл жингээсээ салсан, хөдөлгөөний дутагдал арилсан, 7 хоногт 2 удаа 6 цагийн хугацааг спортоор өрсөлдөж үр дүнтэй өнгөрүүлсэн, нийгэмд залуусдаа зөв үлгэр дууриалал үзүүлсэн, зөв амьдралын



хэвшилд уриалсан зэрэг олон эерэг үр дүнгүүд гарсан.



Өсвөр насны хүүхдүүдэд тамхины хор уршгийн талаар ойлголт мэдээлэл өгөх зорилгоор “ТАМХИГҮЙ ОРЧИН ТААТАЙ” эсээ бичлэгийн уралдаан зарлаад байна.



Дугуй сонирхогчдыг дэмжих, хүүхэд залуучууд, иргэдийн дунд дугуй унах сонирхлыг төрүүлэх ба стресс ядаргаа тайлах, зүрх, уушигны ажиллагаа сайжрах, чихрийн шижин, цусны даралт нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор "ДУГУЙН ФЕСТИВАЛ-2024" арга хэмжээг амийгийн Биүйн тамир, спортын газартай хамтран 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд



- Байгууллага, аж ахуй нэгж, сонирхогчдын дугуйн парад
- Дугуйн худалдаа, солилцоо, засвар үйлчилгээ
- Дугуйн "Шилийн богд" клубын танилцуулга
- Нас бол тоо зурагт үзэсгэлэн
- Хүнсний худалдаа, үйлчилгээ зэрэг үйл ажиллагаа зохион байгуулагдлаа. Мөн 5 насны ангиллаар дугуйн тэмцээн зохион байгуулагдаж нийт давхардсан тоогоор 150 гаруй дугуйчид оролцлоо.



Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох-9, хүүхэд үрчлэх тухай-4 өргөдөл ирснийг 100 хувь шийдвэрлэж, хариу өгч ажиллалаа.

Тайлант сарын байдлаар <https://sukhbaatar.igovernment.mn/> цахим санд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 27, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 арга хэмжээг тус тус хугацаанд нь тайлагнасан.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Үнэлгээ, мониторинг хэрэгжүүлэх замаар гүйцэтгэлийн удирдлага, бүтээмжийг сайжруулах нь сэдэвт сургалтыг бүсчилсэн хэлбэрээр Эрдэнэцагаан суманд зохион байгуулсан.

Тус сургалтад Тамгын газрын бодлого хариуцсан 5 мэргэжилтэн хамрагдсан.

Сургалтад хамрагдсан албан хаагчид сургалтаар олж авсан мэдлэг, мэдээллээ бодлого хариуцсан мэргэжилтнүүдэд хуваалцаж, сургалт зохион байгууллаа. Сургалтыг дараах агуулгаар хийлээ. Үүнд:

Х.Баярмаа-Төрийн байгууллагын цахим ил тод байдлын хэрэгжилтийг хангах, А.Өлзийжаргал- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх арга зүй, Ц.Сайхантуяа-ХШҮ-ний удирдлага, арга зүй, Э.Эрдэнэхүү- Шийдвэрийн төсөл бэлтгэхэд анхаарах асуудал.

Сургалтад 10 мэргэжилтэн хамрагдаж, мэдээлэл авлаа. Мөн байгууллагын мэдээллийн цагаар сургалтын агуулгыг товч хэлбэрээр нийт албан хаагчдад мэдээлсэн.

Сэтгэл зүйн төв үйл ажиллагаа явуулж байна. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвөөр 65 иргэн үйлчлүүлсэн байна. Хохирогч хамгаалах хамгаалах байранд сэтгэл зүйн үйлчилгээ авсан иргэдийн тоо-16. Үүнээс том хүн-5, хүүхэд 11 байна. Хэлбэр нь хүчирхийллийн хэлбэрээр үл хайхрах 4 , бэлгийн хүчирхийлэл 2, гэр бүлийн хүчирхийлэл-5, бусад 5 нийт сэтгэл зүйн үйлчилгээ авсан 16 үйлчлүүлэгч байна.

Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдаж буй хүүхдүүдийн шалтгаан нөхцөл нь өсвөр насны хүүхдүүдийн харилцааны зөрчил маргаан бусдад уруу татагдах хандлага үе тэнгийн дээрэлхэлт, бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах зэрэг асуудлаар холбогдож байна. Мөн сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдаж байгаа иргэд сэтгэл зүйчтэй холбогдон хүүхдийн хүмүүжлийн зан төлөвийн онцлогийн талаар зөвлөгөө авч байна.

Сумын хэмжээнд зудын нөхцөл байдалтай уялдан эд хөрөнгийн хохирол амсаж малгүй болж аймгийн төвд орж ирсэн малчин өрхөд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан 5 дугаар багийн ажлын албанаас нэг малчин өрхийг холбон зуучилж, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулан ярилцлагын тэмдэглэлийг хөтлөж ажиллалаа.

Түр хамгаалах байранд хүлээн авсан хохирогчдод сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг давтамжтай хүргэн, А/74 үндсэн маягтийн дагуу тэмдэглэл хөтлөн ажиллав. Түр хамгаалах байрнаас хамтарсан багийн хурлын шийдвэрээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэй 1, хүүхдийн эсрэг үл хайхрах хүчирхийллийн 2

хүүхдийг хамгаалах байрны үйлчилгээг дуусгавар болгон гаргасан бөгөөд, үйлчилгээ үргэлжлүүлэн авч буй 2 үйлчлүүлэгчид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж байна.

Баруун-урт сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр бүрэн дунд сургуультай хамтран дунд бүлгийн дунд “ЭЕРЭГ ХАНДЛАГА” панел хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

“Урлагийн сэтгэл заслын үндэсний төв” ТББ-аас зохион байгуулсан “Анир чимээгүйг эвдэхүй” гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд урлагийн сэтгэл заслын арга техникээр үйлчилгээ хүргэх сургалтад 9-р багийн Засаг дарга Г.Ган-Оюу, сэтгэл зүйч Л.Оюун нар 5 дугаар сарын 18,19-ны өдрүүдэд хамрагдаж сертификат гардан авлаа.

Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдаж буй иргэдийн шалтгаан нөхцөл нь өсвөр насны хүүхдүүдийн харилцааны зөрчил маргаан бусдад уруу татагдах хандлага үе тэнгийн дээрэлхэлт зэрэг асуудлаар эцэг, эх болон багш холбон зуучлах мөн хүүхдүүд өөрийн хүсэлтээр ирж үйлчилгээ авч байна.

Баруун-Урт сумын хэмжээнд зудын нөхцөл байдалтай уялдан эд хөрөнгийн хохирол амсаж малгүй болж аймгийн төвд орж ирсэн малчин өрхөд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх ажлыг эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд 9 дүгээр багийн ажлын албанаас нэг малчин өрхийг холбон зуучилж, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулан ярилцлагын тэмдэглэл хөтлөн, ажиллалт хийлээ.

Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамрагдаж байгаа иргэд сэтгэл зүйчтэй харилцаа холбоо тогтоох мөн хүүхдийн хүмүүжлийн зан төлөвийн онцлогийн талаар зөвлөгөө авч байна.

Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв нь бүлгийн зөвлөгөөг хэрэгжүүлж байна. Хагас жилийн байдлаар байгууллага дотроо 4 удаа, бусад байгууллагад 4 удаа "Эртэч уулзалт" зохион байгуулж, мэдрэмж нээх бүлгийн сэтгэл засал хийсэн. Бүлгийн сэтгэл заслын уулзалтаар албан хаагчдын мэдрэмжийг ил гаргаж сэтгэл хөдлөлийн олон янз шинж байдлаар илэрхийлэсэн уулзалт болсон.

Сэтгэл зүйн зөвлөгөөний үр ашгийг таниулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагааг сурталчлах, ажлын байрны стресс бууруулах арга замыг таниулах, хамт олны уур амьсгалыг сайжруулах зорилготой сургалт болсон.

“Гэртээ гэрэл асаая III” хөтөлбөр-ийн хүрээнд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв нь “Би бол нар” малчны хүүхдүүдэд зориулсан сургалт зохион байгуулсан. Суралцагч хүүхдүүдээс проктив тест авч, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөний онцлог мэдээллийг хүргэж, зөвлөгөө өгч ажиллалаа.

Дорнод аймгийн “ANNA HOME” асрамжийн газарт тус сумын 4-р багийн иргэн Янсансүрэнгийн Даваажаргалыг (бнастай эрэгтэй) сумын хамтарсан багийн хурлаар хэлэлцэн, шийдвэр гарч, асрамж халамжийн төвд хүлээлгэн өгч, гэрээ байгуулан ажиллалаа.

ANNA HOME асрамжийн газрын Захирал Болдсайхан нь хүүхдийн боловсролын үйлчилгээнд хамруулах, англи хэлний мөн таеквондо дугуйланд

хамруулан хүүхэд хөгжил хамгааллын төлөвлөгөө гарган ажиллах тухайгаа илэрхийлсэн. Асрамжийн газрын хүүхдийг хүлээж авсан багш захиралтай ганцаарчилсан уулзалтыг хийж хүүхдийн тухайн орчинд дасан зохицох байдлыг үнэлэв. Тухайн асрамж халамжийн төвөөс хүүхдийн хувьсах зардал сар бүрийн асран халамжлагчийн хурал, улирал тутмын эргэлтийг хугацаандаа хийх нь зүйтэй талаар санал болгов. Хоёр дахь удаагийн ахуйн хэрэглэл, витаминжуулалтын багцыг хүүхдэд хүлээлгэн өглөө.

ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр:

Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ шаардлагатай хөдөөгийн хүн амд ӨЭМТ-ийн 2 эмчийг томилон, эрүүл мэндийн үйлчилгээг малчны хотонд, 36 иргэнд хүргэж, 46 иргэнд эмийн багц олгон ажиллалаа. Мөн В, С вирусын түргэвчилсэн шинжилгээг-25 хүнд, ХДХВ/ДОХ-ын түргэвчилсэн шинжилгээг-17 хүнд, жирэмслэлтийг эрт илрүүлэх тест шинжилгээнд 7 эмэгтэй хамруулсан.

Гепатитгүй Монгол төслийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран цусаар дамжих халдвар, эрүүл ахуйн халдвар хамгааллын эрсдлээс хамгаалах чиглэлээр Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, ажилчид болон үсчин, гоо сайханч, биеийн шивээс болон энэ төрлийн үйлчилгээ эрхэлдэг 58 иргэнийг сургалтад хамруулсан.

50 аас дээш насны ахмад настанд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, үзлэг, шинжилгээг зохион байгуулсан. Үзлэгт нийт 202 ахмад хамрагдсан. Нарийн мэргэжлийн 10 эмч 493 /давхардсан тоогоор/ ахмадад үзлэг хийж, 12 өвчлөл илрүүлсэн.

Хагас жилийн байдлаар Өрхийн эрүүл мэндийн төв нь гэрийн дуудлага-351, жирэмсний хяналт-742, төрсөн эхийн хяналт-616, нярайн хяналт-643, ахмадын хяналт-1866, ХБИ хяналт-262 нийт 4480 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүллээ.

Гэртээ гэрэл асаа 3 хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийн 30 хүүхдийг Бэсү шүдний эмнэлэгтэй хамтран амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, шүд арчилгаа, амны хөндийн эрүүл мэндийн талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл өгсөн.

“СУВИЛАГЧ ТАНДАА БАЯРЛАЛАА” захидлын уралдааны дүн гарлаа.

Баруун-Урт Засаг Даргын Тамгын Газар, ОД сувилахуйн төвтэй хамтран 2 дахь жилдээ сувилагч мэргэжлийг ард иргэдэд сурталчлан таниулах, зорилготой “СУВИЛАГЧ ТАНДАА БАЯРЛАЛАА” захидлын уралдааныг зохион байгууллаа.

Сувилагч мэргэжлийн онцлогыг уран яруу гаргаж, захидал бичих соёлыг түгээн дэлгэрүүлсэн 20 гаруй захидал ирүүлснээс :

1 дүгээр байр: Г.Ганчимэг /МУИС- оюутан/

2 дугаар байр: Ц.Уранцэцэг /ЭМГазрын эмч/

3 дугаар байр: А.Халиунаа /7-р багийн иргэн/ нар шалгарлаа.



Энхлэн ачтан өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ байрны ээлтийн үйл ажиллагаа боллоо. Тус өрхийн эрүүл мэндийн төв Баруун-Урт сумын 3,4,6,8,9-р багийн 1600 гаруй иргэнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна. Орон нутгийн төсвийн 1,4

тэрбум төгрөгөөр баригдсан 3 давхар тус барилга нэг давхартаа өдрийн эмчилгээ, яаралтай тусламж, дархлаажуулалт, лаборатори, эмэгтэйчүүдийн үзлэгийн өрөөтэй, хүний нөөц 86,5 хувийн хангалттай, 22 эмч, эмнэлгийн ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж байна. Энхлэн ачтан эрүүл мэндийн төвийн нээлтийн арга хэмжээнд УИХ-ын гишүүн Н.Ганибал, аймгийн Засаг дарга М. Идэрбат, Баруун-Урт сумын Засаг дарга Ж.Жавхаатөгс нар оролцлоо.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Энхлэн ачтан Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний 3,4,6,8,9 дүгээр багийн 15-49 насны эмэгтэйчүүдийн үзлэг, шинжилгээ, зөвлөгөө 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 13-17 цагийн хооронд зохион байгуулж, 95 иргэнг хамруулсан.

Спортын клуб, хороодыг дэмжиж ажиллалаа.

Хүн амыг эрүүл чийрэг бие бялдар, өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх, эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, биеийн тамир, спортыг сурталчлах, бүх нийтийн үйл хэрэг болгох зорилгоор “Илүүдэл жингүй-Эртэч Сүхбаатарчууд” бүх нийтийн гүйлтийг тус Тамгын газар, аймгийн Мал эмнэлгийн газар, 1 дүгээр бүрэн дунд сургууль, Өсөх дэлгэр-Ундрах супермаркет хамтран зохион байгуулж, 25 байгууллага, 600 иргэн, төрийн албан хаагчдыг хамрууллаа.

Ерөнхий боловсролын 1,2,3,4-р сургуулиудад стандартын шаардлага хангасан 18 нэр төрлийн тус бүр 112 ширхэг, нийт 5,0 сая төгрөгийн үнэ бүхий спортын хэрэглэгдэхүүн олгосон.

Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн хорооны нэрэмжит “Багш-2023” цомын аварга шалгаруулах волейболын тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцох баг тамирчдад 1,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Өвөрхангай аймгийн Хархорин сумын төвд болох Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан 21 аймгийн Футзалын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон баг тамирчдад 500,000 төгрөг

Мөнгөн цагариг клубээс жил бүр зохион байгуулагддаг Бөхчүүдийн Улсын аварга шалгаруулах Б зэрэглэлийн Сагсан бөмбөгийн тэмцээнд орон нутгаа төлөөлөн оролцох баг тамирчдад 500,000 төгрөг

Хүүхэд залуучууд,иргэдийн дунд дугуй унах сонирхлыг төрүүлэх,бие бялдрыг нь чийрэгжүүлэх,хөдөлгөөний ач холбогдлыг таниулах, дугуй сонирхогчдыг дэмжих зорилгоор “Дугуйн фестивал-2024” арга хэмжээг аймгийн Биеийн тамир спортын газартай хамтран зохион байгуулсан. Дугуйн фестивал-2024 100 гаруй тамирчид оролцсон. Зөв хэвшил-зөв амьдрал хөтөлбөрөөс 1,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Монголын Гимнастикийн холбооноос зохион байгуулсан “Гимнастик -2024” Улсын аварга шалгаруулах Аэробик гимнастикийн тэмцээнд аймаг орон нутгаа төлөөлөн оролцох баг тамирчдад 1,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

ӨМӨЗО-ны Нийслэл Хөх хотод болох Дундад, Монгол,Орос 3 улсын хамтын нөхөрлөлийн 5 дахь удаагийн Бодибилдинг фитнесын “Golden times super series” тэмцээнд оролцох 2 дугаар багийн иргэн Г.Номин-Эрдэнэ-д 300,000 төгрөгийн дэмжлэг олгосон.

Шугаман бүжгийн “Улсын аварга-2024” шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцсон баг, тамирчдад 500,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.Тэмцээнд 12 тамирчин 2 дасгалжуулагчийн хамт оролцож "Эрүүл мэндийн шилдэг"Номниацаар шалгарч, цомын эзэд болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр:

Сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хоёрдугаар чуулган зохион байгуулагдлаа. Чуулганаас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар заалтыг хэрэгжүүлж, хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдсан иргэдэд хувийн туслах ажилтны үйлчилгээг нэвтрүүлэх санаачилга гарсан.

Санаачилгыг Тамгын газраас дэмжин Улаанбаатар хотын Түгээмэл хөгжил төвтэй гэрээ байгуулж, хамтран хувийн туслах ажилтан бэлтгэх сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 16,17-ны өдрүүдэд онол, практик хослуулсан хөтөлбөрийн хүрээнд зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 5 иргэн болон хувийн туслахаар ажиллах хүсэлтэй 10 иргэн нийт 15 хүн хамрагдсан ба 10 иргэнийг хувийн туслах ажилтнаар бэлтгэж, гэрчилгээ олгосон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих сангаас 4,864,000 төгрөг зарцуулсан байна.

Уг арга хэмжээ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд бусдын адил идэвхитэй оролцоход нь туслахын зэрэгцээ цагийн ажил хийж өрхийн орлогоо нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг эрт илрүүлэг, үзлэгт хамруулах ажлыг аймгийн нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ-тэй хамтран зохион байгуулсан. Нийт 167 иргэн хамрагдснаас шинээр онош тодруулах 12 иргэнийг 2,3-р шатлалын эмнэлэгт онош тодруулахаар игээсэн.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын газрын бүртгэлээр хагас жилийн байдлаар байнгын ажлын байранд -42, түр ажлын байранд-27, улирлын чанартай ажлын байранд-2 нийт 71 иргэн зуучлагдан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 109 өрх, 513 иргэн хамрагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан программыг суулган, компьютерын сургалт зохион явуулсан. Сургалтад 6 хүүхэд хамрагдаж, мэдлэг олж авсан.

“Эрхэм нандин сувд” Төрийн бус байгууллага, аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран Улаанбаатар хотод Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв, Улсын 3 дугаар эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн эмч нарын цогц үзлэг оношилгоог үохион байгуулж, 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй 26 хүүхдийг хамруулсан. Үзлэгээр мэдрэл, нүд, шүд, дотор, уушиг, зүрх, бөөр, дотоод шүүрлийн булчирхай, эмгэг судлал, чих хамар хоолойн мэс засал, ерөнхий мэс засал, өсвөр үе, сэргээн засах эмчилгээ, удам зүй, харшил судлал, цусны эмгэг судлал, хэл засал, түнх, үе мөч, ревматология зэрэг 19 нэр төрлийн үзлэг оношилгоо хийж, зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллалаа. Тус арга хэмжээд Засаг даргын нөөц сангаас 1,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн хүүхдүүдэд Очир тулга ХХК-аас тусгай хэрэгсэл 8, 4 улирлын эмчилгээний нумтай гутал 19, тэргэнцэр 1, шууны чиг, зогсоогч зэрэг 4,4 сая төгрөгийн тусгай хэрэгсэл олгосон.

Ахмадуудыг дэмжин ажиллалаа.

Ахмадын хорооны үйл ажиллагаанд 30,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Аймгийн ахмадын хорооноос “Ахмад наснтны чуулган” зохион байгуулсан. Чуулганд Улсын Их Хурлын гишүүд, аймаг сумын удирдлагууд оролцож, тэдний санал бодлыг сонсон, төрийн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийн талаар мэдээлэл өгсөн. Чуулганд 175 ахмад оролцсон.

Аймгийн ахмадын хороо, аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран 50-аас дээш насны ахмад настанг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, шинжилгээнд хамруулсан. Үзлэгийг нарийн мэргэжлийн 10 эмч нийт давхардсан тоогоор 493 ахмад үзлэг хийж, шинэ 12, хуучин 496 нийт 508 өвчлөл илрүүлсэн байна.

Үзлэгээр дотор-60, мэдрэл-61, хавдар-3, эмэгтэйчүүд-5, чих хамар хоолой-24, нүд-53, мэс засал-19, ЭХО-134, рентген-134 тус тус үзүүлсэн.

Үзлэгт хамрагдсан ахмад настанг эмчлэх төлөвлөгөөг гарган өдрийн эмчилгээнд хамруулж, мөн дараагийн шатлалын эмнэлэгт илгээн, эмчилгээ, зөвлөгөө өгч ажилласан.

Боловсрол, соёл, хүүхэд гэр бүлийн чиглэлээр: 2024-2025 оны хичээлийн жилд сургуульд орох 6-н настнуудын нэрчилсэн дэлгэрэнгүй судалгааг гарган аймгийн БШУГ-т файлаар илгээсэн. Нийт 668 хүүхэд суралцахаар байна.

Хүүхдийн утас 108-д тайлант улиралд нийт 6 дуудлага ирсэн. 3 кейсыг хааж, 3 кейсыг хяналтад авч ажиллаж байна.

"Жаахан шаргын нутаг" монгол бичгийн уралдаан зохион байгууллаа.

Жил бүр бичиг үсгийн баярыг угтан Үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор тус сумын Засаг даргын Тамгын газар, Урлагийн боловсролыг дэмжигч "ТИТЭМ-АРТ" академийн харьяа "АРИГУН АРТ" галерей, Боловсрол, шинжлэх ухааны газар, Насан туршийн боловсрол төв хамтран уламжлал болгон зохион байгуулдаг "ЖААХАН ШАРГЫН НУТАГ" Монгол бичгийн уралдаан зохион байгуулагдлаа.



онцлог боллоо.

Энэ жилийн уралдаан хүрээгээ тэлж бүсийн хэмжээнд зохион байгуулагдсан. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын харьяат Монголын зохиолчдын эвлэлийн шагналт, сэтгүүлч, яруу найрагч Ишийн Батсүхийн нэрэмжит болгон зохион байгуулж байгаагаараа

Тус сумын Засаг даргаас өөрийн сумын харъяаны сургууль, цэцэрлэгүүдийн захирал, эрхлэгч нартай 2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, ажлын чиглэл бодлого танилцуулга хийж, мэдээлэл солилцлоо. Мөн Баруун-Урт сумын харьяа ОНӨҮГазрууд болон боловсролын салбарын удирдлагууд, нягтлан бодогч, нярав нарт төсөв санхүү, хууль тогтоомжийн мэдээлэл өгөх зорилгоор сургалт зохион байгууллаа.

Сургалтаар тус суманд 2024 онд улс, аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг Засаг дарга Ж.Жавхаатөгс танилцуулсан бол сумын Тамгын газрын санхүүгийн алба, аймгийн ХБТХОХэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Мөнхтуяа, Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Б.Наранцэцэг, Архивын тасгийн дарга Я.Оюунзул нар үйл ажиллагаандаа анхаарах асуудлын талаар мэдээлэл, зөвлөмж өгсөн.

Сумын Засаг дарга Ж.Жавхаатөгс сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай хамтран ажиллах гэрээ, ОНӨААТҮГазрын дарга нартай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгууллаа. Сургалтад нийт 65 хүн хамрагдсан.



Соёлын чиглэлээр: 7 дугаар багийн иргэн Баттайвангийн Энхтөгөлдөр, Энхсайханы Ялгуунтөгс, Эрдэнэбаатарын Мөнхзолбоо нар нь иргэдэд соёлын боловсрол олгох, түгээн дэлгэрүүлэн, сурталчлах зорилгоор “Эгшигт аялгуу” хамтын уран бүтээлийн тайлан тоглолтоо хийхэд дэмжлэг үзүүллээ.

Дорноговь аймагт зохион байгуулагдах Монголын үсчин гоо засалчдын “Зүүн болон говийн бүс”-2024 аварга шалгаруулах тэмцээнд сумаа төлөөлөн оролцож буй үсчин, гоо сайханч, хумс урлаачдад дэмжлэг үзүүллээ.

Үлгэрч сүхбаатарчууд уралдаан зохион байгуулагдлаа. Бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөрийн хүрээнд Үлгэрч Сүхбаатарчууд уралдааныг аймгийн СУГазраас зохион байгуулсан. Уг уралдаанд Дарьгангачуудын аман билэг соёлын өвийг хадгалсан дарьганга үлгэрийг сурталчлан таниулах ардын авьяастнуудыг тодруулах зорилготой зохион байгуулагдснаараа онцлог байлаа. Дээрх уралдааны 3 насны төрлөөр шалгаруулсан бөгөөд ардын аман билгийн авьяастнуудын төлөөлөл тус сумаас дараах иргэд оролцлоо. Үүнд: Үлгэрч өвөө эмээ - Б. Баянжаргал, Г.Довдондорж, Үлгэрч аав, ээж - С.Өнөржаргал -Үлгэрч ах эгч - Х.Ууганзаяа нар оролцож, Үлгэрч эмээ өвөө төрөлд ахмад ардын авьяастан Б. Баянжаргал Дэд байр эзэллээ.

Нархан хүүхдийн сувиллын үйл ажиллагаа эхэллээд байна. Нархан хүүхдийн сувилал 4 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. Тус сувилалд 2-5 насны онцгой хяналтын суурь эмгэгтэй, дархлаа дутмагшилтэй өвчлөмтгий хүүхдүүдийг 3 ээлжээр нийт 150 хүүхэд хамруулна.

Сувилалд нь өдрийн эмчилгээний 5 хоолтой сүү, тараг, ногоо, аминдэм, эрдэс бодисоор баялаг сувиллын хоолоор үйлчилж, бариа засал, ясны шөл, шар сүү, сүү, хар цай гэх мэт эмийн бус уламжлалт эмчилгээнүүд хийгдэж байна.

Сувилалд мэргэжлийн эмч, сувилагч, тогооч, багш нар ажиллаж эмчилгээ үйлчилгээг үзүүлж байгаараа онцлогтой.

Сүхбаатар аймгийн хүүхдийн элч Ж.ЖАВХААТӨГС “Ярилцах цаг” нэвтрүүлэг хийлээ.

“Гэртээ гэрэл асаая ” III хөтөлбөрийн хүрээнд “Би бол нар” малчны хүүхдүүдэд зориулсан арга хэмжээ зохион байгуулагдлаа.

“Гэртээ гэрэл асаая II” хөтөлбөрийн сургагч багш нар, сумын сэтгэл зүйн төвтэй хамтран “Би бол нар” малчны хүүхдүүдэд зориулсан сургалт хөгжлийн 1 сарын хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

Хүүхэд бүрийн нас сэтгэл зүйн онцлогт тохирсон сургалт, хөгжлийн үйл ажиллагаа, сэтгэл зүйн зөвлөгөө хосолсон тус хөтөлбөрт 30 хүүхэд хамрагдаж, 1 сарын турш хамтдаа хөгжлөө.



Хүүхэд хамгааллын чиглэлээр:Баруун-Урт суманд аймгийн аварга хүлэг шалгаруулах "Жавхлан шарга-2024" уралдааныг 5 насны 225 хурдан морины уралдаан зохион байгууллаа. Дээрх уралдааныг хүүхдийн эрх аюулгүй байдал болон холбогдох дүрэм журмыг мөрдөн зохион байгуулсан. Уг наадамд морь унаач 58 хүүхэд, 22 алдарт уяачид хүүхдийн эрх аюулгүй байдал хамгаалалтын хувцас хэрэглэл, даатгалын талаарх мэдээллийг Гэр бүл хүүхэд хөгжлийн газар, Жавхлант шарга морин спортын газруудтай хамтран зохион байгуулсан.



"Харилцан хүндэтгэж тэгш оролцоог хангая" 1 сарын аяны хүрээнд Баруун-урт сумын Засаг даргын Тамгын газраас Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч нарт жендерийн талаарх суурь ойлголт, үе тэнгийн дээрэлхэлт, эрсдэлээс хамгаалах мэдлэг чадвар олгох сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Сумын Хамтарсан багийн төлөвлөгөө гарган сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргаар батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөө хэрэгжилт 70 хувьтай байна.

Худалдах авах ажиллагааны чиглэлээр:

Төсвийн тухай хуулийн дагуу 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг иргэдээсээ авч эрэмбэлж, 2024 оны үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөртэй уялдуулан нийт 55 нэр төрлийн ажил, мөн урьд оны өрийг тусган 4,145.3 сая төгрөгийн ажил хийхээр төлөвлөж, ИТХ-аар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тендер зарласан: Үүнээс

Тендер хүлээн авах шатандаа 16, тендер хүлээн авах шатандаа-11, тендер үнэлэх шатандаа-1, гэрээ байгуулсан-4, шууд худалдан авалтын журмаар 6 ажил зохион байгуулаад байна. Нийт ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна

Нийт 33 ажил зарлан зохион байгуулахаас 16 ажил зохион байгуулсан.

3 дугаар сургуулийн тохижилтод хөгжим, техник хэрэгсэл гардууллаа.

"Багш хөгжлийн кабенетийн тохижилтын ажил" орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр төсөв батлагдаж Бандо электроникс ХХК 75,745.0 мянгөн төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж ажлыг сумын Засаг даргын А/169 тоот захирамжаар

байгуулсан ажлын хэсэг хүлээн авч 3 дугаар сургуулийн захиргаанд хүлээлгэн өглөө. Багш, ажилчдын тав тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлж ухаалаг самбар 2, зөөврийн компьютер 11, олон үйлдэлт хувилагч 2, принтер өнгөт 2, зурагт 2, хөгжим техник зэргийг гардууллаа.

Саруул хотхоны гадна талбайн тохижилтын ажил 80% байна

2 дугаар багийн Саруул хотхоны гадна талбайн тохижилтын ажлын тендер 2023 онд 10 удаагийн давтамжтай цахимаар зарлан зохион байгуулж амжилтгүй болсон. Тендерт эцсийн шалгаруулалтаар Хайлааст гарам ХХК 59,967.7 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч 2024 оны 05 сард ажил эхлүүлж 06 сард хүлээлгэн өгөхөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан. Тус ажлын хэрэгжилтийг "Сүхбаатар хот байгуулалт, орон сууц, барилга захиалагчийн газар" Орон нутгийн өмчит Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Ажил 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Багш, ажилчдын тав тухтай ажиллах, сурагчдын сурч, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн "Багшийн хөгжлийн кабинетын тохижилт"-ын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 151,0 сая төгрөг батлагдсан. Тус ажлыг tender.gov.mn сайтаар 2 багц болгон цахимаар зарласан. Тавилга хэрэгсэл нийлүүлэх тендерт Өүби жийн центр ХХК 47,920.0 мянган төгрөг, Тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт Бандо электроникс ХХК 75,745.0 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч тендер бараа хүлээн авах шатандаа явагдаж байна.

Байгаль орчин, хот тохижилтын чиглэлээр:

Нийтийн эзэмшлийн зам дагуу нарс мод суулгалаа: Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хотын өнгө үзэмжийг сайжруулах, эрүүл эко орчин бүрдүүлэх хүрээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нарс мод худалдан авах ажлыг шууд худалдан авалтын журмаар зохион байгуулж гүйцэтгэгчээр Хэнтий аймгийн Биндэр сумын Сум дундын ойн ангитай 2,400.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, сумын Засаг даргын А/135 тоот захирамжаар байгуулсан ажлын хэсэг 30 ширхэг нарс модыг хүлээн авч ажиллалаа.

"Маргаашийн хоггүй хуудсыг хамтдаа эргүүлцгээе" хаврын их цэвэрлэгээ зохион байгууллаа. Сумын Засаг даргын А/85 тоот захирамжаар "Хаврын бүх нийтийн цэвэрлэгээг "Маргаашийн хоггүй хуудсыг хамтдаа эргүүлцгээе" уриан дор 03 дугаар сарын 25-наас 04 дүгээр сарын 25-ны хугацаанд зохион байгууллаа.

Уг ажлын хүрээнд аж ахуй нэгж, байгууллагуудад хог хаягдлын тухай хуулийн дагуу орчны 50 м болон хуваарьт газраа цэвэрлэхийг Засаг даргын албан тоотоор мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Нийт 20 гаруй аж ахуй нэгж,



байгууллага цэвэрлэгээ хийсэн тайлан ирүүлсэн.

Уг ажилд ОНХС-10,000000 төгрөгийг зарцуулсан. 151 удаагийн ачилтаар 236 тонн хог хаягдлыг хогийн цэг рүү зөөвөрлөсөн. Ачигчаар 23 иргэн, жолоочоор 15 иргэн, 14 иргэнийг нийтийн эзэмшлийн зам талбай цэвэрлүүлэх ажилтнаар авч ажиллуулсан.

“Маргаашийн хоггүй хуудсыг хамтдаа эргүүлгээ” 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр ЕБС-ын 2,3 сургууль, МБСургууль 750, 46 багш, ажилчид хамрагдаж,



цэвэрлэгээ зохион байгуулсан.

Байгаль орчин жуулчлалын яамны санхүүжилтээр Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулахаар, Баруун-Урт сумын 9 дүгээр баг, 8-р багийн нутаг дэвсгэрт 3-н байршилд 50 га, 10га, 10 га буюу нийт 70 га газрын хэмжилт судалгаа, төлөвлөгөөг хийж, саналыг хүргүүлээ.

Байгаль орчны хамгаалах тухай, БОНБҮнэлгээний байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй Цэвэр усны үйлдвэр-1, Мах боловсруулах үйлдвэр-1, ШТС-4, нийт 6 аж ахуй нэгжийн 2023 оны Байгаль орчны менежментийн тайланг дүгнэж, тайлан мэдээг аймгийн БОГазарт хүргүүлсэн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүгнэлтээр 90%+ биелэлттэй 2, хангалтгүй буюу 90%-аас доош биелэлттэй 4 аж ахуй нэгж байна.

Аймгийн төвийн ногоон байгууламжийг хамгаалах зорилгоор Мал гаргах ажлыг эрчимжүүлэх тухай төлөвлөгөө гарган ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу Сүхбаатар тохижилт үйлчилгээ ӨНӨААТҮГ, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨААТҮГ, Баруун-Урт сумын Тамгын газар 7 хоног бүрийн амралтын өдрийг хариуцан нийтийн эзэмшил, ногоон бүст орж ирсэн малыг гаргах, хөөх, малын хашаанд хаших ажлыг 02 дугаар сарын 28-ныг хүртэл хариуцан гүйцэтгэсэн. Хотын төвд орж ирсэн 10 үхрийг журмын хашаанд оруулах, 15 үхэр, 12 адууг хотын захаас хөөж гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн. Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨҮГазрын журмын хашаанд орсон

малын эзэнд аймгийн цагдаагийн газраас Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм эсрэг зөрчлөөр торгуулийн арга хэмжээг 10 иргэнд ногдуулсан.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан 72 аж ахуй нэгж, байгууллага эзэмшил болон хуваарьт газраа 19111 мод тарьлаа.

Сумын Засаг даргын “Ажил эрчимжүүлэх тухай” 01 тоот албан даалгавраар аймгийн төвийн ногоон байгууламжийн хашааны хамгааллыг сайжруулах, нөхөн сэргээх талаар Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨҮГазарт үүрэг болгож, төвийн ногоон байгууламж 462 ш хайлаас модонд татагдсан торон хашаа, Сүхбаатарын талбайн зүүн тал, Дөрвөлж цэцэрлэгт хүрээлэнгийн төмөр хашаа зэрэг эвдэрсэн, сунасан хашааг засварлах ажил хийгдсэн. Мөн Амгалан хорооллын баруун талаар ногоон байгууламжийн хамгааллалтын хашааг хийхээр төлөвлөж, хашаа нийлүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах шатанд ажиллаж байна.

Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа хийх ажлыг Шаргын модод ХХК-тай гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд хяналтыг тавьж ажиллаж байна. гэрээний хугацаанд буюу 06 сарын 01-нээс 10 сарын 20-ны хугацаанд 7880 ширхэг модны усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна. Мөн төвийн ногоон байгууламжийг Ойжуулалт хайлаас ХХК 4000 ш, Сүхбаатар ойжуулалт сум дундын ойн анги 15 мянга, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ОНӨҮГазар тойргийн 10 гаруй мянган модны усалгаа арчилгаа тус тус хариуцан гүйцэтгэж байна.

Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээний хүрээнд сумын 7-р багийн хувиараа бизнес эрхлэгч иргэн Э.Ганболор нь 2024 оноос эхлэн эко ариун цэврийн жорлонг хямд өртөгөөр үйлдвэрлэн нийлүүлж байна. Иргэдийг эко нойлтой болохын ач холбогдлыг таниулсан мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж ажиллалаа.

Хагас жилийн байдлаар 10 танк, 7 өрхийн эко жорлон буюу 17 өрхийн бохирын цооног, жорлонг захиалгын дагуу хийж, байршуулаад байна.

2023 оны 11 сарын 06-наас эхлэн их хэмжээний цас орж, нийтийн эзэмшлийн зам талбайд хальтиргаа гулгаа үүссэн. Тус сумын Засаг даргын Тамгын газраас албан тоотоор төрийн байгууллагуудын нийтийн эзэмшлийн зам талбай дахь цэвэрлэгээний хуваарийг хүргүүлж, хэрэгжилтэд 2-3 удаа хяналт тавьж ажиллалаа. Хяналтын дүнд 42 байгууллага, 27 аж ахуй нэгж орчны 50 м болон хуваарьт газрын цэвэрлэгээг үйлчилгээг 1-2 удаа хийж, тайланг тус Тамгын газарт ирүүлсэн.

Байгаль орчны хамгаалах тухай, БОНБҮнэлгээний байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А618 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж буй ШТС-8, мах боловсруулах үйлдвэр-2, цэвэр усны үйлдвэр-1, 2023 оны Байгаль орчны менежментийн тайланг дүгнэж, тайлан мэдээг БОГазарт хүргүүлсэн. БОМ-ийн төлөвлөгөөний дүгнэлтээр 90%+ биелэлттэй 4, хангалтгүй буюу 90%-аас доош биелэлттэй 7 аж ахуй нэгж байна

4-н сургуулийн эко клубын сурагч нартай хамтран хаврын бүх нийтээр мод тарих өдөр Байгаль орчны газрын бичил саданд 86 ширхэг мод тарьсан. Сүхбаатар аймгийн хүүхдийн зөвлөл, эко клуб мод тарих хүсэлт ирүүлсний дагуу нисэх буудлын торны баруун талд 270ш модны нүх ухах ажлыг нийтийн хамарсан төслөөр хэрэгжүүлж, 100 хайлаас модны дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Дэд бүтэцийн чиглэлээр: 7 дугаар багт байрлах гадна 10 КВ-ын ЦДАШ, 10/04 КВ-ын 50КВА-н хүчин чадалтай АТП дэд станц, тэдгээрт тоноглогдсон эд материалуудыг худалдан авах гэрээг Ай си ай фүүдс ХХК-тай байгуулж гэрээний дагуу хүлээн авсан. Тус станцын өргөтгөл хийгдсэнээр 5 болон 7 дугаар багийн 140 гаруй өрхийн цахилгааны хүчдэл унах, тог тасрах гэсэн асуудлууд шийдэгдсэн.

4 дүгээр багийн цамхагт гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд сумын 2024 оны төсөвд 15 сая төгрөг батлагдсан. Уртын гэгээ ОНӨААТҮГ-тай гэрэлтүүлгийн ажилд шаардаргдах материалыг худалдан авч, суурилуулах ажлын гэрээ байгуулан, хүлээн авсан.

Худалдааны гудамжны авто замын хучилт засварын зураг, төсөв боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр Классик роуд ХХК-тай 20 сая төгрөгөөр, 5, 6, 9-р багийн тоглоомын талбайн засвар, шинэчлэлийн ажлын зураг төсөв боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр ЛФКС ЛАНДШАФТ ХХК-тай 14 сая төгрөг, 1, 4, 5, 6-р багийн тоглоомын талбайн засвар, шинэчлэлийн ажлын зураг төсөв боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр ЛФКС ЛАНДШАФТ ХХК-тай 18 сая төгрөгөөр тус тус гэрээ байгуулж зураг төсвийг зургийн даалгавар болон гэрээний дагуу хүлээн авах ажлууд хийгдсэн. Магадлан дүгнэлтээр баталгаажсан зураг төсвийн хүрээнд 7 тоглоомын талбайн засвар, шинэчлэлт, 2 явган замын засварын ажлын тендерүүд зарлагдсан.

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

Үерийн эрсдэлтэй бүсийн судалгааг гарган, зургийн даалгавар боловсруулж, компаниас үнийн санал авсан. Тус зургийн даалгаварт их хэмжээний борооны улмаас ус тогтож айл өрхүүд хашаа, гэр рүүгээ ороход хүндрэлтэй байдал үүсдэг 5-р баг, Дэнж хэсгийн 15 гудамж, 4-р баг, Төмөртэй хэсгийн 3 гудамжны шороон замыг хайрган дэвсгэр дэвсэж тэгшлэх, ус зайлуулах суваг татах ажил хийгдэхээр төлөвлөж боловсруулсан.

Сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр 100,0 сая төгрөг ИТХ-аар батлуулсан. Хаягжуулалтыг шинэчлэх журмын төслийг 8 дугаар сард Засгийн газрын хурлаар оруулахаар мэргэжлийн байгууллага ажиллаж байна.

Нийтийн орон сууцнуудын шугам сүлжээний засвар, шинэчлэлийн ажилд 126,477сая төгрөг батлагдсан. Дөрвөлж ОНӨААТҮГ Газар нь тус ажлын төсвийн судалгааг гаргахдаа гүйцэтгэх ажлын хөлс бодолгүйгээр бараа материал худалдаж авахаар тооцож гарсан. Үнэлгээний хороо байгуулагдсан, тендерийн баримт бичиг боловсруулах шатандаа явж байна.

Зургийн даалгаврыг боловсруулж зураг, төсөв боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр ЛФКС ЛАНДШАФТ ХХК-тай гэрээ байгуулсан. Тус компани нь

тоглоомын талбайн засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсвийг магадлан дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэн өгсөн. Батлагдсан зураг, төсвийн хүрээнд тендер зарлагдсан. одоогоор гүйцэтгэгч тодроогүй байна.

2023 онд магадлан дүгнэлтээр баталгаажсан зураг, төсвийн дагуу тендер зарлагдсаж 2023 оны 11 дүгээр сард гүйцэтгэгчээр Хайлааст гарам ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээ байгуулан тус ажлыг 2024 оны 4 дүгээр сард хийж эхэлж 5 дугаар сард хийж дуусгасан. Ажлын гүйцэтгэл 100 хувь дууссан захиалагчийн хяналтыг гүйцэтгэж компанид комисс томилж хүлээж авах хүсэлтийг өгсөн санхүүжилт авах бичиг баримтаа бүрдүүлж байна.

2023 онд магадлан дүгнэлтээр батлагдсан зураг, төсвийн дагуу тендер зарлагдаж гүйцэтгэгчээр Хайлааст гарам ХХК шалгарч 2023 оны 11 дүгээр сард ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, 2024 оны 4 дүгээр сард ажилаа гүйцэтгэж эхэлсэн. Ажлын талбайг бэлтгэх явцад тус ажлын авто зам, явган замын трассд дулааны шугам сүлжээний худаг таарч байсан. Ажлын зурагт дулааны худаг байхгүй байсан ба хийх ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй ажил гарч ирсэн. Ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулах бол зохиогчийн зөвшөөрөл хэрэгтэй байдаг. Зохиогчийг ирж ажлын талбайтай танилцаж зурагт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Гүйцэтгэгч компани ажлын талбайд шаардагдах бараа материалыг татсан.

Худалдааны гудамжны авто замын хучилт, засварын ажлын зургийн даалгаврыг боловсруулж зураг, төсөв боловсруулах ажлыг гүйцэтгүүлэхээр Классик роуд ХХК-тай гэрээ байгуулсан. Тус компани нь худалдааны гудамжны замын хучилт, засварын ажлын 687,0 сая төгрөгний төсвийг боловсруулж магадлан дүгнэлтээр баталгаажуулан хүлээлгэн өгсөн.

Сумын 2024 оны төсөв батлах тухай 2023 оны 22/06 дугаар ИТХ-ын тогтоолд худалдааны гудамжны тохижилтын ажилд нэг тэр бум төгрөг батлагдсан.

Батлагдсан төсөвт өртөгт багтсан ажил хийлгэхийн тулд 2-р сургуулийн урд талын зогсоол хүртэл үргэлжлүүлэн авто замын хучилт, засварын ажлыг хийлгэхээр 567,0 сая төгрөгний төсөвтэй ажлын зургийг хийлгэсэн.

Бусад:

Хагас жилийн байдлаар 9-н багийн 32 иргэнд 3,100,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна.

Малын тоо толгойн албан татварын өмнөх онуудын үлдэгдэлтэй малчин, мал бүхий өрхүүдэд сумын онцгой комиссын шийдвэрээр өвс, тэжээлийн дэмжлэг олгох үеэр мэдээллийг өгсөн бөгөөд малчин болон мал бүхий иргэдээс малын тоо толгойн албан татварыг татан төвлөрүүлсэн. Нийт 900 гаруй иргэдэд татварын талаарх мэдээллийг өгсөн. 28,239,462.00 сая төгрөгийн татвар төлөгдсөн.

2025 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр багт хийгдэх ажлын санал асуулгыг нийт 9-н багаас цахим 706, цаасан санал 2118 авч ажилласан байна.

Цэргийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 2024 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 01 дүгээр сарын 22-ны өдрийн хооронд харъяа багийн 18-50 насны цэргийн бэлтгэл үүрэгтэн эрэгтэйчүүдийг, үүнд харъяалагдах тусгай нэр томъёо бүхий хамаарах мэргэжлийн иргэдийг бүртгэж ажилласан. Үүнд: -55 хүртэлх насны бэлтгэл офицер, ахлагч -

60 хүртэлх насны бэлтгэл ахлах офицерыг хамруулан бүртгэсэн. Багийн нэгдсэн дүнгээр 18-50 насны дайчилгааны эрчүүдийг 73 хувьтай хамрагдсан.

2024 оны 1-р ээлжийн хаврын цэрэг татлагын үзлэгт хамрагдах тус сумын 18-25 насны 547 залууд зарлан мэдээллэх хуудас өгөхөөс 463 цэргийн зарлан дуудах хуудас өгсөн. Зарлан мэдээ тараалтын хувь 84.6% байна.

60 хэсгийн ахлагч нарыг чип гэрт хуваарийн дагуу гарган, иргэдэд төслийн талаар мэдээлэл хүргэж ажиллалаа. Хэсгийн ахлагч нар айл өрхөөр явж, төрийн мэдээллийг хүргэн, 400 ширхэг сонин, 500 ширхэг брошур тараасан.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “ЖАРГАЛТАЙ БАГАЧУУД” өдөрлөгийг зохион байгууллаа. Уг өдөрлөгийн арга хэмжээнд 120 орчим хүүхэд, багачууд оролцсон. Хүүхдүүд дундаас бяцхан авьяастнуудын авьяасыг нээх зорилгоор OPEN MIC арга хэмжээ, АХА тэмцээн, бага насны хүүхдүүдийн дунд гүйлтийн тэмцээнийг зохион байгуулсан.

Арга хэмжээнд оролцсон хүүхдүүдэд багийн ажлын албанаас ном, витаминаар урамшуулсан. Арга хэмжээг ЦОНЛХА дэлгүүр ивээн тэтгэж, хамтран ажиллалаа.

Сүхбаатар аймгийн Угсаатны зүй музейтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 20 иргэнд монголын баялагаа танин мэдэх арга хэмжээ зохион байгуулсан.

"Уртын гэгээ" ОНӨҮГ-тай хамтран Сүхбаатар аймагтаа хийгдэж буй бүтээн байгуулалтын танилцуулах зорилгоор "БИДНИЙ БАХАРХАЛ" аялалыг зохион байгуулсан. Аялалд 1 дүгээр багийн 24 ахмад хамрагдсан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН:

А.ӨЛЗИЙЖАРГАЛ